



**ЗАВХАН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 26 өдөр

Дугаар А/344

Улиастай

Ногоон байгууламж, аялал жуулчлалын  
"Жавхлант цогцолбор" бий болгох тухай


Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1.15 дахь заалт, 60 дугаар зүйлийн 60.1.16 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1.Иргэдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх, ая тухтай амрах, аюулгүй орчныг бүрдүүлсэн, явган хүний зам, гэрэлтүүлэг, камержуулалт, усан оргилуур, амралтын талбай, автомашины зогсоол бүхий ногоон байгууламж, аялал жуулчлалын "Жавхлант цогцолбор"-ыг байгуулсугай.

2."Жавхлант цогцолбор"-ыг байгуулах ажлын гүйцэтгэл, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах явцад хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Азжаргал)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар Хууль, эрх зүйн хэлтэс (У.Батдаваа)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ӨНӨРБАЯР

Захирамж\_А4

8169010944